

АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ

1. БАРАА МАТЕРИАЛЫН ТАВИГДАХ ШААРДЛАГА

Ерөнхий шаардлага

1. Ачааны машин болон нэмэлт төхөөрөмжүүд -40°C -аас $+40^{\circ}\text{C}$ хүртэлх орчинд ажиллах шаардлагатай.
2. Дизель хөдөлгүүр (ачаалал, жин, хэмжээ, бартаат замын нөхцөлд тохиромжтой байх).
3. Автомат хурдны хайрцагтай.
4. Уурхайн талбай, шавар, цас, чулуутай замаар явах өндөрлөг тэнхлэгтэй.
5. 1 урд тэнхлэг, 2 хойд тэнхлэг буюу нийт 10 дугуйтай.
6. Савны багтаамж 10,000-12,000 литр / 10м^3 - 12м^3 .
7. Том, жижиг хоёр түлш хуваарилах хошуутай.
8. Түлш сорох шахуургын холболттой.
9. РТО төхөөрөмжөөр холбогдох, салгагдах шахуурга.
10. Түлшний хуваарилагч төхөөрөмжийг машины ард байршуулж, шүүгээ болгон зохион байгуулах.

Шатахууны сав

1. Дотор тусгаарлагчгүй, зөвхөн нэг төрлийн түлш хадгалах зориулалттай.
2. Нийт эзэлхүүн 10 - 12м^3 буюу 10,000-12,000 литр.
3. Түлшний хөдөлгөөнийг сааруулах дотор хуваагчтай.
4. Зэвэрдэггүй ган материалаар хийгдсэн, түлшний чанарт сөрөг нөлөөгүй.
5. Цэвэрлэхэд хялбар байх.
6. Хэмжилтийн болон дээж авах люктэй.
7. 500-600 литр/мин хурдтай ачилтад тохирсон амьсгалах хавхлагатай.
8. Дээрээ гулсдаггүй шат тавцантай.
9. Унах эрсдэлээс сэргийлэх хашлага бүхий хамгаалалттай.
10. Түлш ачих холболт савны хажууд байрлана.

Түлш сорох насос

- Нэмэлтээр 3” түлш сорох насос, 10м урт хоолойтой байх.

Түлшний шүүгээ

Тайлбар: Шахуурга, шүүлтүүр, тоолуур, хоолой ороогч, газрын холбогч утас, яаралтай хаах унтраалга, халаагуур зэрэг төхөөрөмжүүдийг савны арын шүүгээнд байрлуулна.

1. Өвлийн улиралд ашиглах зориулалттай арын шүүгээний халаагуур.
2. Дижитал дэлгэцтэй, $\pm 0.1\%$ нарийвчлалтай тоолуур.

3. 1” жижиг цэнэглэх хошуу, эргэлдэгч холбогч, автомат хоолой ороогч, 15м урт хоолой.
4. Flowmax 2” цэнэглэх хошуу, эргэлдэгч холбогч, автомат хоолой ороогч, 15м урт хоолой.
5. Зөвхөн дизель түлшинд тохирсон 5-10 микрон давхар шүүлтүүр, урсгалын хурд 300-350 литр/мин (-40°C-аас +40°C).
6. Шахуургын урсгалын хурд 300-350 литр/мин (-40°C-аас +40°C).
7. Бүх хоолой ороогч автомат, гидравлик болон цахилгаан ажиллагаатай (-40°C-аас +40°C).



Аюулгүй байдлын төхөөрөмжүүд

1. Аюулгүй ажиллагааны түгжээ / Яаралтай хаах систем.
2. Агаарын тоормостой зогсоолын горим.
3. Гурван ширхэг 4-5 кг гал унтраагч (хоёр талд, нэг нь кабинд).
4. Асгаралт хянах хэрэгсэл болон тоног төхөөрөмжийн хайрцаг.
5. Статик цэнэгийн газрын холбогч утас.
6. Тэмдэглэгээ, анхааруулга (тамхи татахыг хориглоно, шатамхай, галын хоолой, унтраалга, яаралтай тусламж, евро-5 дизель гэх мэт).
7. Арын камер.

Гэрэлтүүлгийн систем

1. Нэмэлт урд болон хойд гэрлүүд.
2. Цэнэглэх талбай болон хоёр хажуу, арын нэмэлт гэрэлтүүлэг.
3. Нэмэлт харагдах орчны толь.



2. НИЙЛҮҮЛЭХ ХУВААРЬ

Энэхүү ажлын хүрээнд үйлчилгээ, барааг дараах хугацаанд нийлүүлнэ:
Төлөвлөсөн гол үе шат

- 2025/07/15 - ОТ талбайд бэлтгэл ажил эхлүүлэх (Хариуцагч: ОТ/Гэрээт гүйцэтгэгч)